

**“ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗАР” ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛГИЙН  
“ГАМШИГИЙН АЮУЛЫН ТУХАЙ ЗАРЛАН МЭДЭЭЛЛИЙН ДОХИО”-НЫ  
ДАГУУ ДАДЛАГА, СУРГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ**

2022.03.24

Улаанбаатар хот

Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоолоор жил бүрийн 03 дугаар сарын дөрөв дэх долоо хоногийн Лхагва гарагийг “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр” болгон шийдвэрлэсэн.

Харин Засгийн газрын 2011 оны 339-р тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”-д зааснаар жил бүрийн 03 дугаар сарын дөрөв дэх долоо хоногийн Пүрэв гарагийн 16 цагт улс орон даяар гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургууль хийж, бэлэн байдлыг ханган ажиллана гэж заасан байдаг.

Энэ дагуу 03 дугаар сарын 24-ний өдрийн 16:00 цагт орон даяар гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага байгууллагын хэмжээнд зохион байгуулав.

Өргөө амаржих газар төлөржсөн мэргэшлийн эмнэлгийн Албаны штабын дарга -Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга О.Баянжаргал удирдаж үйл ажиллагааг зохион байгуулав.

Тус ажлын хүрээнд “Өргөө амаржих газар” төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг 2022.03.24-ний 16:00 цагт дуут дохио дуугарахад 4-6 минутын хугацаанд ажил дээрээ албан үүрэг гүйцэтгэж байсан эмч, эмнэлгийн ажилтнууд, мөн эмнэлгийн амбулатори, хүлээн авах яаралтай тусламжийн хэсэгт үзүүлэхээр ирсэн иргэд, гарах боломжтой өвчөтнүүд болон тэдний ар гэрийхнийг байгууламжаас гаргаж төлөвлөсөн цугларах талбайдаа цугларч аюулгүй байдлаа хангах арга хэмжээнд оролцов.

Хамрагдсан нэгжүүдийг тус бүрээр нь дурьдвал:

Төрсний дараах хэсэг – 13

Эрсдэлтэй жирэмсний тусламжийн тасаг – 13

Нэгдсэн мэс засал, мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний тасаг – 15

Нэгдсэн хүлээн авах тасаг - 9

Нярайн тасаг – 25

Эрүүл мэндийг дэмжих тасаг – 19

Захиргаа – 28

Эмэгтэйчүүдийн тасаг – 15

Хангамж үйлчилгээний алба – 9

Ариутгал, угаалгын алба - 14

Эм зүй – 9

Байгууллагын зарлан дуудах схемийн дагуу 11 нэгжийн 169 эмч, эмнэлгийн ажилчид, амбулатори, хүлээн авахаар үйлчилгээ авч байсан иргэд болон түүний ар гэрийнхэн нийт 24 хүн хуулинд заасан үүрэг хариуцлагаа ухамсарлан сайн дурын үндсэн дээр амжилттай хамрагдав.

Мэс засал болон төрөлт, эмчилгээ үзүүлж буй нийт 28 эмч, ажилчид дотор ажиллаж ажлын байран дээрээ үлдэв.

Эмнэлгийн гадаад орчин, дотор орчинд давхар бичлэг хийж, зураг авч баримтжуулж танилцуулганд хавсаргав.

Байгууллагын <http://urquu-amarikh.ub.gov.mn/> цахим хуудсанд мэдээллийг байршуулсан болно.

**“ГАМШИГИЙН АЮУЛЫН ТУХАЙ ЗАРЛАН МЭДЭЭЛЛИЙН ДОХИО” дуугарч байх үед**



**Зураг 1, 2** Эхний дохио дуугарахад иргэн та “суу, нүүгд, хүлээ” гэсэн дүрмийг баримталж аль болох шил, цонхноос хол, бат бөх ширээн доогуур орж бие болон толгойгоо халхлан аюулгүй байдлаа хангаж буй байдал





**Зураг 3,4.** Хоёр дахь дохио дуугарахад хамт олноороо байгаа бол толгойгоо халхлан яарч сандралгүй нэгийн цуваанд орж баруун гар талаа барьж, “гүйхгүй, эргэж буцахгүй, нэгнээ түлхэхгүй” гэсэн дүрмээ баримталж, байгаа газраасаа гарч, аюулгүй талбайд цугларна. Гарахдаа цахилгаан шат ашиглахгүйгээр гарч буй байдал



**Зураг 5,6** Гурав дахь дохио дуугарахад та өөрийн байгууллагынхаа холбогдох албан тушаалтанд бүртгүүлж, гэр бүлийн гишүүд, анги хамт олны мэдээллийг үнэн зөв тодорхой өгч буй байдал



**Зураг 7,8** Байгууллагын дотор өрөөнүүдийн хаалга,гарцуудыг чөлөөлж онгойлгов.



**Зураг 9,10** Байгууллага дээр хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчид өөрсдийгөө хамгаалж буй байдал

Хянасан:Албаны штабын дарга

Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга

Тайлан бичсэн: ХЭААБХАжилтан

О.Баянжаргал

М.Дэлгэрбаяр